



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/273

Булган сум

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх
тусгай зөвшөөрлийн тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1, 8.1 дүгээр зүйлийн 12 дугаар хэсгийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох цэгийн нэрийг 1 дүгээр, үйлдвэрлэх цэгийн нэрийг 2 дугаар, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр солих цэгийн нэрийг 3 дугаар хавсралтаар баталсугай.

2. Энэхүү Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/150 дугаар захирамжийн Г.Гантуяа захиралтай "Миний голомт" ХХК-ийн "Өсөн Аривжих-1" хүнсний дэлгүүртэй холбогдох заалтыг хүчингүйд тооцсугай.

3. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2-т заасан тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга, Татварын газар (Д.Лхагвасүрэн), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (хурандаа Б.Эрдэнэбилэг), Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай), сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР

Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010385

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дүгээр сарын 25-ны/ний өдрийн
А/273 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ” ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭРС**

д/д	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл	Бар, ресторан, дэлгүүрийн нэр
1	2	3	4	5	6
1	Булган сум 6-р баг Хужиртолгой 6А-3-306 тоот “Suits”	“Гангат -Од” ХХК	Б.Оюунболд	Супермаркет	“Гангат”
2	Хутаг- Өндөр сум 1-р баг 147 б	“Их хаадын хүнс” ХХК	П.Ариунсайхан	Хүнсний дэлгүүр	“Их хаад”
Нийт-2					

Аймгийн Засаг даргын 2025 оны
01 дүгээр сарын 25-ны ний өдрийн
А/223 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**УЛАМЖЛАЛТ ТЕХНОЛОГИОР СОГТУУРУУЛАХ УНДАА ҮЙЛДВЭРЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИХ ЦЭГИЙН НЭР**

д/д	Сумын нэр, хаяг байршил	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний төрөл
1	2	3	4	5
1	Хангал сум 1-р баг, Сөрт, Сэлэнгэ мөрөн-1	"Хуурай Арал хоршоо"	Н.Оюунгэрэл	"Монгол архи үйлдвэрлэх"

Аймгийн Засаг даргын 2025 оны
 0 дүгээр сарын 25 ны/ний өдрийн
 А/273 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН НЭР СОЛИХ ЦЭГИЙН НЭР**

д/д	Сумын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч		Үйлчилгээний төрөл	Оноосон нэр	Шинээр тусгай зөвшөөрөл эзэмших		Оноосон нэр
		Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр			Аж ахуйн нэгжийн нэр	Захирлын овог, нэр	
1	2	3	4	5	6	7	8	9
1	Булган	"Миний гал голомт" ХХК	Г.Гантуяа	Хүнсний дэлгүүр	"Өсөн Аривжих-1"	"Буян машид дэлгэрүүлэгч" ХХК	М.Норовсамбуу	"Баян мандал"
	Нийт-1							